



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 171

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын баталсан 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 2.1.2, 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын албан хэрэгцээнд зориулан 2020 оны улсын төсөвт тусгагдсан нийт 400,000,000.00 (дөрвөн зуун сая) төгрөгт багтаан хавсралтад заасан хөрөнгийг олж авахыг зөвшөөрсүгэй.

2. Авлигатай тэмцэх газрын Тамгын газрын дарга, эрхэлсэн комиссар 3.Баасаннямд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого,  
зохицуулалтын газрын 2020 оны  
04 дүгээр сарын 27-ний өдрийн  
171 дугаар тогтоолын хавсралт

**Авлигатай тэмцэх газрын худалдаж авах хөрөнгийн үнийн дээд  
хязгаар**

Д/д	Хөрөнгийн нэр	тоо ширхэг	Нийт үнэ (төгрөгөөр)
1	Суудлын автомашин /жижиг/	5	400,000,000.00
			400,000,000.00
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>400,000,000.00 (дөрвөн зуун сая)</b>